

이주 외국인근로자를 위한

## 법률 핸드북

-E-9 비자 보유자를 중심으로-

Гадаад ажилчдад зориулсан хууль зүйн мэдлэг олгох гарын авлага

- E-9 визтэй иргэдэд зориулав -

법무법인(유) 율촌 · 사단법인 온율/ KB 국민은행

## 목 차

### Гарчиг

#### 머리말

Orshil

#### I. 한국에 입국하여 해야 할 일

##### I. Солонгос улсын хил нэвтэрсний дараа хийх ёстой зүйлсүүд

1. 출입국관리법에 따른 ‘외국인등록’ 신고하기

2. <표준근로계약서> 정확하게 알기

①근로계약서란?

②취업규칙이란?

③<표준근로계약서> 내용 살펴보기

④<표준근로계약서> 작성 시 유의사항

1. “Гадаадын иргэд хилээр нэвтрэх тухай хууль” -д заасны дагуу “Гадаад иргэдийн бүртгэл”-д бүртгүүлэх тухай

2. <Хуулийн дагуу хийгдсэн хөдөлмөрийн гэрээ>- ний талаар зөв, тодорхой мэдээлэлтэй болох тухай

①Хөдөлмөрийн гэрээ гэж юу вэ?

②Ажилд орох журам гэж юу вэ?

③<Хуулийн дагуу хийгдсэн хөдөлмөрийн гэрээ>- ний агуулгатай танилцах тухай

④<Хуулийн дагуу хийгдсэн хөдөлмөрийн гэрээ>-г байгуулах үедээ анхаарах зүйлсүүд

#### II. 한국에서 일하면서 겪을 수 있는 문제

1. 이럴 때는 어떻게 해야 하나요?

①사업주가 임금/퇴직금을 주지 않아요.

②소액체당금제도는 어떻게 이용할 수 있나요?

③근로계약서에 정한 시간보다 더 많이 일을 시켜요.

④여권과 외국인등록증을 사업자가 보관하겠다고 해요.

⑤일을 하다가 다쳤어요. 산재신청은 어떻게 하나요?

⑥한국에 온 유학생이 구직을 하려면 어떻게 해야 하나요?

▲ 이주민상담기관 안내

2. 사업장 변경 신청하기

#### II. Солонгос улсад ажиллаж амьдрахад үүсч болох бэрхшээлүүд

1. Доор дурьсан тохиолдлуудад асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

- ① Ажил олгогч цалин эсвэл ажлаас халагдсаны мөнгийг олгохгүй байх тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?
  - ② Авч чадаагүй цалингаа авахын тулд “Төрийн төлөөлөн олгох” хөтөлбөрт хэрхэн хамрагдах вэ?
  - ③ Хөдөлмөрийн хуульд заасан цагаас илүү цагаар ажиллуулсан тохиолдолд яах вэ?
  - ④ Хөдөлмөр эрхлэгчийн гадаад паспорт болон Солонгос улсад оршин суух гадаад иргэний үнэмлэхийг ажил олгогчийн зүгээс хадгалах санал тавьсан тохиолдолд яах вэ?
  - ⑤ Ажлын байран дээр гэмтсэн тохиолдолд гэнэтийн ослын даатгалд хэрхэн хамрагдах вэ?
  - ⑥ Тус улсад суралцаж төгссөн гадаад оюутан ажилд орохыг хүсвэл хэрхэн ажлын байраа хайх вэ?
- ▲ Гадаад иргэдэд зөвлөгөө өгөх байгууллагын талаарх танилцуулга
2. Ажлын байраа солих тухай

### **III. 한국에서 체류하면서 알아두어야 할 내용- 외국인 근로자와 보험**

1. 4대 보험의 개요
2. 국민건강보험
3. 산업재해보상보험
4. 국민연금
5. 고용보험

### **III. Солонгос улсад оршин суухугацаандаа заавал мэдвэл зохих зүйлсүүд**

1. Заавал хамрагдах 4 төрлийн даатгалын танилцуулга
2. Эрүүл мэндийн даатгал
3. Гэнэтийн ослын даатгал
4. Тэтгэврийн даатгал
5. Хөдөлмөрийн даатгал

### **IV. 귀국 할 때 참고하여야 할 내용**

1. 불법체류에 따른 불이익
2. 고용허가제전용보험 보험금 수령
  - ①출국만기보험
  - ②귀국비용보험
3. 국민연금반환일시금청구
4. 세관신고
5. 외국인근로자 본국 한국기업 취업
6. 취업 활동기간 만료 시 재고용 및 재입국
7. 귀국근로자 네트워크 참여

### **IV. Эх орон руугаа буцахдаа зайлшгүй мэдэж байх ёстой зүйлсийн жагсаалтууд**

1. Хууль бусаар оршин суухтай холбоотойгоор үүсч болох сөрөг үр дагаварууд
2. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой даатгалын мөнгөө хэрхэн авах тухай
  - ① Эх оронруугаа буцах даатгал
  - ② Эх оронруугаа буцах замын зардлын даатгал
3. Тэтгэврийн даатгалд төлсөн татвараа буцаан авах тухай
4. Гаалийн татвар
5. Эх орондоо очсоны дараа солонгос байгууллагад ажиллахыг хүсвэл яах ёстой вэ?
6. Хөдөлмөр эрхлэх хугацаа дууссан болон уг хугацааг сунгах, дахин Солонгос улсын хилээр нэвтрэн орж ирэх тухай
7. Солонгос улсад ажиллаж байгаад эх орондоо буцсан ажилчидтай хэрхэн харилцаа холбоо тогтоох вэ?

## **머리말**

이 핸드북은 이주 외국인근로자들이 한국에서 생활하는 데 꼭 필요한 기본적인 법률 지식을 담고 있습니다. 이 핸드북에 담긴 내용은 주로 <외국인근로자의 고용 등에 관한 법률>에 따라서 외국인 근로자 고용허가를 받은 사업장에 취업하는 외국인근로자(E-9 비자보유자)를 대상으로 한 것입니다만, 그 중에 많은 부분은 그 밖의 이주 외국인근로자에게도 적용될 수 있습니다.

이 소책자는 한국어로 작성된 원고를 외국어(몽골어, 미얀마어, 베트남, 캄보디아어)로 번역한 것입니다. 정확한 번역을 하기 위하여 해당 언어를 말 할 수 있는 여러 분들이 많이 수고해 주셨지만, 원래 번역은 어려운 작업이며, 법률 관련 문서의 번역은 더욱 어렵기 때문에, 원문의 내용이 충실히 옮겨지지 못한 부분이 있을 수 있음을 양해해 주시기 바랍니다.

앞으로 기회가 닿는 대로 내용을 수정, 보완하고 번역도 다듬고자 합니다.

이 매뉴얼이 이주 외국인근로자들이 한국에서 잘 정착하고 자신의 정당한 권리를 보호 받는 데 도움이 되기를 기대합니다.

## **Оршил**

Энэхүү гарын авлага нь гадаад иргэд солонгос улсад оршин суух хугацаандаа зайлшгүй мэдвэл зохих анхан шатны хууль эрх зүйн мэдлэг, мэдээллүүдийг эмхтгэсэн болно. Гарын авлагын гол агуулга нь солонгос улсад ажиллаж буй нийт гадаад иргэд болон тэр дундаа тус улсын<Гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэх тухай хууль>-д заасны дагуу гадаадын ажиллах хүчийг ажиллуулах зохих зөвшөөрөл бүхий байгууллагуудад ажиллаж буй гадаад иргэн(E-9 ангилалын визтэй) –д түлхүү хамааралтай болно.

Гарын авлагын эх нь солонгос хэл дээр бэлтгэгдэн гарсан ба илүү олон хүнд хүргэх үүднээс гадаад (Монгол, Мьянма, Вьет남, Камбуж)хэл тус бүр дээр орчуулагдсан болно. Бичгэн орчуулга гэдэг хоёр хэлийг холбосон нэр их хөдөлмөр байдаг билээ. Тэр тусмаа хууль, эрх зүйн чиглэлийн орчуулга нь орчуулагчаас энэ талын мэдлэг, орчуулгын чадварыг илүү ихээр шаарддагаараа онцлогтой юм. Хэрэв энэхүү гарын авлагыг унших зуур орчуулгын мэр сэргээх алдаа анзарагдвал эрхэм та мэргэн ухаанаараа шүүж үзэхийг хүсж байна.

Цаашдаа орчуулгын талын мэр сэргээх алдаануудыг засаж залруулах тал дээр анхааран ажиллах болно.

Эцэст нь энэхүү гарынavalga нь солонгос улсад ажиллаж амьдарч буй гадаад иргэдэд тулгамдсан олон асуудлуудыг нь шийдвэрлэхэд болон өөрийн хууль ёсны эрхээ хамгаалуулахад нь тус дэм болно гэдэгт найдаж байна.

## I. 한국에 입국하여 해야 할 일

### I. Солонгос улсад орж ирснийхээ дараа хийх ёстой зүйлсүүд

#### 1. 출입국관리법에 따른 ‘외국인 등록’ 하기

이 매뉴얼이 주대상으로 하는 E-9 비자를 보유한 외국인근로자를 포함하여 우리나라에서 일하기 위하여 적법한 비자를 받고 입국한 모든 외국인은 출입국관리소에 ‘외국인 등록’을 할 의무가 있습니다. 외국인등록과 외국인등록증은 대한민국 국민의 주민등록 및 주민등록증과 비슷한 역할을 하며, 은행거래, 주택임대차 보호 등 실생활을 위하여 꼭 필요합니다.

#### 1. Гадаад иргэд “Хилээр нэвтрэх тухай” хуульд заасны дагуу “Гадаад иргэдийн бүртгэл”-д бүртгүүлэнэ

Энэхүү гарын авлагад дурьдагдаж буй E-9 앙吉利린 viztэй гадаад иргэд болон бусад бүхий л төрлийн визийг эзэмшигч гадаад иргэд “Гадаад иргэдийн улсын хилээр нэвтрэх асуудлыг хариуцсан хэлтэс” -т өөрийн биеэр очиж “Гадаад иргэний бүртгэл”-д хамрагдах ёстой. Гадаад иргэний бүртгэлд хамрагдсанаар олгогдох оршин суух үнэмлэх нь гадаадын иргэний хувьд Солонгос улсын иргэний үнэмлэх гэсэн үг тул банкинд гүйлгээ хийх, орон сууц түрээслэх гэх мэтчилэн бүхий л зүйлсэд зайлшгүй шаардагдах бичиг баримт юм.

##### 1) 외국인 등록신고

외국인근로자는 한국에 입국한 날부터 90일 이내에 출입국관리사무소에 외국인등록을 신청해야 합니다. 외국인등록을 위해서는 외국인등록신청서, 여권, 사진 1장(4.5cm x 3.5cm), 사업자등록증사본, 수수료를 제출해야 합니다. 외국인등록이 되면, “외국인등록증”을 받게 됩니다. 이 “외국인등록증”을 잘 보관하고 항상 지니고 다녀야 합니다.

##### 1) Гадаад иргэний бүртгэл хийлгэх

Гадаадаас ирсэн хөдөлмөр эрхлэгч нь Солонгос улсын хилээр нэвтрэн орж ирснээс хойш 90 хоногийн дотор “Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар”-т Гадаад иргэний бүртгэлийг хийлгэнэ. Бүртгүүлэхдээ гадаад паспорт, 1 хувь цээж зураг(4.5cm x 3.5cm), ажиллаж буй байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, шимтгэл хураамжийн хамт бэлдэнэ. Бүртгэлийн явц дууссанаар “Orшин суух үнэмлэх” олгогдох бөгөөд энэхүү үнэмлэхийг биедээ байнга авч явах ёстой болно.

##### 2) 외국인등록사항변경신고

외국인등록을 할 때에 신고했던 사항이 변경된 때에는 14일 이내에 출입국관리사무소에 “외국인등록 사항변경신고”를 해야 합니다. 외국인근로자의 성명, 성별, 생년월일 및 국적이 변경된 경우, 여권번호, 발급일자 및 유효기간이 변경된 경우에는 신고해야 합니다.

외국인등록에 관한 자세한 사항은 출입국관리사무소의 웹사이트에 잘 나와 있으며, 이 웹사이트는 영어로도 볼 수 있으므로 궁금한 점이 있으면 참고하시기 바랍니다

## 2) Гадаад иргэний бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай

Анхлан хийлгэсэн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах шаардлагатай болсон тохиолдолд уг өөрчлөлтийн талаар 14 хоногийн дотор “Гадаадын иргэн, харьятын асуудал эрхлэх газар”-т мэдэгдэнэ. Гадаадын иргэний овог нэр, хүйс, төрсөн он сар өдөр, улсын харьяалал, гадаад паспортын дугаар, олгогдсон өдөр, хүчинтэй хугацаа зэрэг заалтууд өөрчлөгдсөн тохиолдолд тухайн өөрчлөлтийн талаар мэдэгдэнэ.

Гадаад иргэдийн бүртгэлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэлийг “Гадаадын иргэн, харьятын асуудал эрхлэх газар” -ын цахим хуудаснаас харах боломжтой бөгөөд сайтын мэдээлэлийг англи хэл дээр тохируулан үзэх боломжтой болно.

## 2. 표준근로계약서 정확하게 알기

<외국인근로자의 고용 등에 관한 법률>에 의하면 E-9 비자를 받고 우리나라에서 일하기 위하여 입국하는 외국인근로자는 고용노동부가 정한 “표준근로계약서”에 따라서 근로계약서를 체결하도록 되어 있습니다.

## 2. <Хуулийн дагуу хийгдсэн хөдөлмөрийн гэрээ>- ний талаар зөв, тодорхой мэдээлэлтэй болох

<Гадаад иргэдийг ажиллуулах тухай хууль>-д заасны дагуу E-9 앙길الын визийг эзэмшигч нь Хөдөлмөрийн яамнаас тогтоосон “Хуулийн дагуу хийгдсэн хөдөлмөрийн гэрээ”-г байгуулна.

### ①근로계약서란?

근로계약서는 근로시간, 임금, 휴가 등 중요한 근로조건을 기재한 계약서입니다. 일하기 전에 반드시 작성해야 하며, 총 2부 작성하여 사용자와 근로자가 각각 1부씩 나누어 가집니다. 외국인근로자에게도 한국의 근로기준법 등 노동관계법령이 그대로 적용됩니다. 근로기준법에는 임금, 근로시간 등 근로조건의 최저기준을 정하고 있으며, 근로계약서는 근로기준법에 위반되는 내용으로 작성할 수 없습니다.

근로기준법에 따르면 사용자는 다음과 같은 행위를 할 수 없습니다.

- 사용자는 국적을 이유로 근로조건에 대한 차별적 처우를 하지 못합니다.
- 사용자는 폭행, 협박, 감금 등의 수단으로써 강제근로를 시키지 못합니다.
- 근로계약 불이행에 대한 위약금 또는 손해배상액을 미리 정하는 계약을 체결하지 못합니다.

- 근로계약에 덧붙여 강제저축 또는 저축금의 관리를 규정하는 계약을 체결하지 못합니다.

## ① Хөдөлмөрийн гэрээ гэдэг нь?

Хөдөлмөрийн гэрээ гэдэг нь ажлын цаг, цалин хөлс, амралт зэрэг чухал асуудлуудыг хуулийн дагуу тэмдэглэн баталгаажуулсан бичиг баримт бөгөөд ажил эрхлэгч нь ажил олгогчтой хамтран ажиллаж эхлэхээс өмнө уг гэрээг байгуулан 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг нэгээр нь хадгалан үлдээнэ. Гадаадын иргэдтэй байгуулах хөдөлмөрийн гэрээ нь Солонгос улсын иргэнтэй байгуулдаг хөдөлмөрийн гэрээтэй утгын хувьд адил байхаар тогтоон заасан байдаг бөгөөд “Хөдөлмөрийн хэм хэмжээний талаарх хууль” болон “Хөдөлмөрийн хууль”тай холбоотой заалтууд нь ижил агууламжтайгаар тусгагдсан байна. Хөдөлмөрийн хэм хэмжээний тухай хууль нь цалин хөлс, ажлын цаг, ажлын нөхцөл зэргийг хамгийн тохиромжтой хэмжээгээр улсаас тогтоосон хуулийн заалт бөгөөд хөдөлмөрийн гэрээг байгуулахдаа энэхүү хуулийн заалтуудыг зөрчиж өөрчлөлт оруулахыг хориглоно.

Хөдөлмөрийн хэм хэмжээний тухай хуулийн дагуу дараах зүйлсийг үйлдэхийг хориглоно.

- Ажил олгогч нь ажилтныг гадаад хүн гэсэн шалтгаанаар ялгаварлан гадуурхах
- Ажил олгогч нь ажилтанг хүчирхийлэх, дарамтлах, хорих зэрэг хууль бус байдлаар албадан ажиллуулах
- Ажил олгогч хөдөлмөрийн гэрээний улмаас үүсэж болох эрсдлийн талаарх хохирол барагдуулах ба ингэхдээ хохирол үүсэхээс өмнө урьдчилсан эрсдлийг таамагдасан байдалтайгаар (мөнгөн дүн олгох гэх мэт) урьдчилсан гэрээ байгуулахыг хориглоно
- Ажил олгогч хөдөлмөрийн гэрээний хавсралт болгон албадан мөнгөн хуримтлах, мөнгөн хуримтлалтай холбоотой эрхийг гардан авах тухай гэрээ байгуулах

## ② 취업규칙이란?

상시근로자 10인 이상의 사업장에는 취업규칙을 작성하여 게시를 하여야 하는데, 근로계약서와 마찬가지로 취업규칙도 근무조건을 정하고 있으므로 확인을 해야 합니다. 취업규칙은 소속사업장의 근로자들이 준수해야 할 복무규율과 임금, 근로시간 등 근로조건에 관한 구체적인 사항을 사용자가 정한 문서를 말합니다. 취업규칙과 관련하여 중요한 사항은 다음과 같습니다.

- 사용자는 취업규칙을 근로자가 자유롭게 열람할 수 있는 장소에 항상 게시하거나 갖추어 두어 근로자에게 널리 알려야 합니다.
- 취업규칙에서 정한 기준에 미달하는 근로조건을 정한 근로계약은 그 부분에 관해서 무효가 됩니다.
- 취업규칙의 작성 또는 변경에 관하여 해당 사업 또는 사업장에 근로자의 과반수로 조직된 노동조합이 있는 경우에는 그 노동조합, 근로자의 과반수로 조직된 노동조합이 없는 경우에는 근로자의 과반수의 의견을 들어야 합니다. 다만, 취업규칙을 근로자에게 불리하게 변경하는 경

우에는 그 동의를 받아야 합니다.

② Хөдөлмөрийн дотоод журам гэж юу вэ?

10-аас илүү тооны байнгын ажилтантай ажлын байранд хөдөлмөрийн дотоод журмын заалт бичгийг олон нийтэд ил харагдахаар газар бичин тавих ёстой бөгөөд энэхүү журам нь хөдөлмөрийн гэрээний нэгэн адил хөдөлмөрийн хэм хэмжээг тусгасан байдаг тул ажилтан хүн уг журмыг нягтлан уншиж танилцсан байх ёстой. Хөдөлмөрийн дотоод журам гэдэг нь харьялагдаж буй албан газрын үйл ажиллагааны явцад даган мөрдөх журам болон цалин хөлс, ажлын цаг, ажлын нөхцөл зэргийн талаар дэлгэрэнгүй байдлаар тусгасан баримт бичиг болно. Доорх заалтууд нь хөдөлмөрийн дотоод журмын чухал заалтууд болно.

- Ажил олгогч нь хөдөлмөрийн дотоод журмыг ажилчдад хүссэн үедээ нягтлан үзэж болохуйц газар байрлуулан тавьсан байна.
- Хуульнд тогтоогдсон заалтыг хөдөлмөрийн дотоод журманд буруугаар тусгасан тохиолдолд энэхүү журмын заалт нь хүчин төгөлдөр байдлаа алдана.
- Хөдөлмөрийн журмыг батлах, өөрчлөхтэй холбоотой заалтыг тусган оруулахдаа байгуулгын нийт ажилчдын талаас илүү хувь элсэн орсон “Хөдөлмөрчдийн эвсэл” байгуулагдсан байвал уг эвсэлийн саналыг, уг эвсэл байхгүй байх тохиолдолд нийт ажилчдын талаас илүү хувийн саналыг тусган оруулна. Ингэхдээ дотоод журмын агуулга нь ажилчдын эрхийг хөндсөн агууламжтай байх тохиолдолд энэ заалттай холбоотойгоор ажилчдын зөвшөөрөл заавал авсан байна.

③ <표준근로계약서> 내용 살펴보기

표준근로계약서는 ①농업·축산업분야에 사용되는 표준근로계약서와 ②제조업을 비롯한 나머지 분야에 사용되는 표준근로계약서로 구분됩니다. 그 양식은 부록1과 같습니다. 이 근로계약서에서 정한 내용은 사업주뿐 아니라 외국인근로자도 잘 지켜야 합니다. 외국인근로자가 한국 입국 후 사업주가 새로 근로계약을 체결하자고 하는 경우가 있습니다. 이 때는 반드시 표준근로계약서로 작성해달라고 요구하고 새로운 계약서의 내용을 잘 살펴보아야 합니다. 근로자가 새로운 계약서의 내용에 동의하지 않는다면, 계약을 다시 체결할 필요는 없습니다.

③ <Хуулийн дагуу хийгдсэн хөдөлмөрийн гэрээ>- ний агуулгатай танилцах  
**Хуулийн дагуу хийгдсэн хөдөлмөрийн гэрээ нь**  
нэгдүгээрт. Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарын хөдөлмөрийн гэрээ, Хоёрдугаарт. Үйлдвэрлэл болон бусад салбарын хөдөлмөрийн гэрээ гэж хоёр томоохон хэсэгт хуваагдана(гэрээний загварыг 1-т хавсаргав). Хөдөлмөрийн гэрээнд заасан агуулгыг гэрээнд оролцогч талууд болох ажил олгогч, ажил эрхлэгч нар чандлан биелүүлнэ. Гадаад ажилтанд ажил олгогчийн талаас Солонгос улсад ирснийх нь дараа хөдөлмөрийн

гэрээг дахин шинээр байгуулах хүсэлт тавих тохиолдол гардаг ба энэ тохиолдолд гэрээг “Хуулийн дагуу хийгдсэн хөдөлмөрийн гэрээ”-ний жишгийн дагуу байгуулах хүсэлтээ ажил олгогчид тавьж, шинээр байгуулах гэрээний агуулгатай сайтар танилцана. Хэрэв шинээр байгуулах гэрээний агуулгатай санал нийлэхгүй тохиолдолд уг саналаас татгалзах эрхтэйгээ санах нь зүйтэй.

○ 근로계약기간

사업주는 근로계약서에서 정하는 기간 동안 외국인근로자를 고용해야 합니다. 외국인근로자도 이 기간 동안에는 마음대로 근무지를 옮길 수 없습니다. (물론 특별한 사정이 있어서 사업장변경절차를 거친 경우에는 가능합니다)

○ Xөдөлмөрийн хуулийн хугацаа

Ажил олгогч нь хөдөлмөрийн гэрээнд заасан хугацааны туршид хөдөлмөр эрхлэгчийг ажлаар хангана. Ажилтан нь энэ хугацааны туршид ажлын байраа өөрийн дураар солих боломжгүй(хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд ажлын байрны өөрчлөлтийн талаарх мэдэгдлийг хийснээр солих боломжой болно).

○ 근로장소

근로자가 일하기로 정한 장소입니다. 사업주는 근로계약서에서 정한 장소에서만 일을 하게 하여야 합니다.

○ Aжлын байр

Ажилтан гэрээ хийхдээ тогтсон ажилаа хийх ба ажил олгогч нь хөдөлмөрийн гэрээнд заасан ажлын байранд ажилтныг ажиллуулана.

○ 업무내용

근로자가 하기로 한 일의 종류가 기재된 것입니다

○ Хийх ажлын агуулга

Ажилтны хийх ажлын төрөл зүйлийг тусгасан байна.

○ 근로시간

근로기준법에의하면, 근로시간은 1일에8시간, 1주일에 40시간 이하여야하고, 1일 8시간을 초과하거나, 1주일 40시간을 초과하여 근무하는 경우“연장근로”에 해당합니다. “연장근로”는 원칙적으로는 1주일에 12시간을 한도로 할 수 있습니다. (주의사항: 근로자가 4명 이하인 직장에서 일하는 근로자와 농업/축산업/어업사업장에서 일하는 근로자에게는 근로시간을 제한하는 법이 적용되지 않습니다.)

○ Aжлын цаг

Хуулийн дагуу хийгдсэн хөдөлмөрийн гэрээнд ажлын цагийг өдрийн 8 цаг, 7 хоногийн 40 цагаар хязгаарлан заасан байдаг. Өдрийн 8 цагаас илүү цагаар ажилласан тохиолдолд “Илүү цагийн хөдөлмөр” гэж үзнэ. 7 хоногт илүү цагийн хөдөлмөрийн хэмжээг 12 цаг хэмээн тогтоосон болно(анхаарах зүйлс: 4- ээс доош ажилтантай газар ажилладаг болон

хөдөө аж ахуй, загас агнуурын салбарт ажилладаг ажилтны хувьд дээрх хуулинд заасан ажлын цагийг хязгаарлан тогтоосон заалт хамаarahгүй болно).

#### ○ 휴게시간

근로기준법에의하면, 일하는 시간이 4시간 이상이면 30분, 8시간 이상이면 1시간 이상의 휴게시간을 사용할 수 있습니다. (주의사항: 농업/축산업/어업사업장에서 일하는 근로자에게는 근로시간을 제한하는 법이 적용되지 않습니다.)

#### ○ Амралтын цаг

Хөдөлмөрийн хуулинд заасны дагуу 4 цагаас дээш ажилласан бол 30 минут, 8 цагаас дээш ажилласан бол 1 цагаас дээш амарч болно. (анхаарах зүйлс: 4-ээс доош ажилтантай газар ажилладаг болон хөдөө аж ахуй, загас агнуурын салбарт ажилладаг ажилтны хувьд дээрх хуулинд заасан ажлын цагийг хязгаарлан тогтоосон заалт хамаarahгүй болно).

#### ○ 휴일

근로기준법에서는 근로자는 1주일에 1회 이상의 유급휴일을 받을 수 있다고 정하고 있습니다. (주의 사항: 농업/축산업/어업사업장에서 일하는 근로자에게는 휴일에 관한 법이 적용되지 않습니다. 따라서 근로계약에서 휴일을 어떻게 사용할지 정하게 됩니다.)

#### ○ Амралтын өдөр

Хөдөлмөрийн хуулинд ажилтан 7 хоногийн 1-ээс дээш өдөр амрах эрхтэй гэдгийг тусган заасан байдаг. (анхаарах зүйлс: 4-ээс доош ажилтантай газар ажилладаг болон хөдөө аж ахуй, загас агнуурын салбарт ажилладаг ажилтны хувьд дээрх хуулинд заасан ажлын цагийг хязгаарлан тогтоосон заалт хамаarahгүй болно. Тиймээс энэ тохиолдолд амралтын өдрийг хөдөлмөрийн гэрээнд нарийвчлан тусгана).

#### ○ 임금

근로자의 임금은 법으로 정하는 시간당 “최저임금” 보다 많아야 합니다. 근로자는 “기본급”이 시간당 최저임금보다 많은지 살펴보아야 합니다. 만약에 근로자가 “월급”을 받고 있다면, 월급을 한달에 일하는 시간으로 나눈 금액이 “최저임금”보다 커야 합니다. 2017년의 시간당 최저임금은 6,470원입니다.

사업주와 약정한 근로시간(소정근로시간) 이상으로 연장근무한 시간에 대해서는 임금의 50%를 더 받을 수 있습니다. 예를 들어, 시간당 임금이 1,000원이면, 연장근무한 시간에 대해서는 시간당 1,500원을 받게 됩니다. 오후10시부터 다음날 오전 6시까지의 사이에 일한 경우에는 “야간근로”에 해당하고, 야간에 일한 시간에 대해서는 임금의 50%를 수당으로 더 받을 수 있습니다. 휴일에 일하는 경우에도 “야간근로”를 한 경우와 같이 50%의 수당을 받을 수 있습니다. (주의사항: 근로자가 4명 이하인 직장에서 일하는 근로자와 농업/축산업/어업사업장에서 일하는 근로자에게는 수당을 지급하는 법이 적용되지 않습니다.)

### ○ Цалин хөлс

Ажлын хөлсийг хуулинд “Цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ”-дүйцхүйц эсвэл дээгүүр хэмжээтэй байхаар тогтоож заасан байдаг. Ажилтан нь үндсэн цалин “Цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ”-нээс дээгүүр тогтоосон эсэхийг нягтлан шалгах хэрэгтэй. Ажлын хөлсөө сард тогтсон нэг өдөр авдаг бол цалингийн хэмжээг нэг сарын хугацаанд ажилласан нийт цагтаа хуваан нэг цагийн ажлын хөлсийг тооцож гаргана. 2017 оны байдлаар “Цагийн хөдөлмөрийн хөлний доод хэмжээ” нэг цагт 6.470 вон байхаар тогтоосон болно.

Ажил олгогчтой байгуулсан гэрээнд заасан ажлын цагийг сунган “илүү цагаар” ажилласан тохиолдолд үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний хөлсийг нэмэлтээр авахаар тусгана. Жишээ нь: Цагийн хөдөлмөрийн хөлсний хэмжээ 1000 вон гэж бodoход та нэг цаг илүү ажилласан бол энэхүү мөнгөн дүнгийн 50 хувьтай тэнцэх мөнгөн дүн болох 500 вон буюу нийт 1500 вон авна гэсэн үг. Хэрэв та оройн 22 цагаас өглөөний 06 цаг хуртэл ажилласан бол энэ нь шөнийн ээлжийн ажилд хамрагдах бөгөөд ингэсэн тохиолдолд мөн адил цалингийн 50 хувьтай тэнцэх мөнгийг нэмэлтээр бодуулан авна. Амралтын өдөр ажилласан бол үүнтэй мөн адил цалингийн 50 хувьтай тэнцэх мөнгийг илүү цагийн хөлсөнд авна(анхаарах зүйлс: 4-ээс доош ажилтантай газар ажилладаг болон хөдөө аж ахуй, загас агнуурын салбарт ажилладаг ажилтны хувьд дээрх хуулинд заасан ажлын цагийг хязгаарлан тогтоосон заалт хамаарахгүй болно).

### ○ 임금지급일

사업주가 근로자에게 임금을 주는 날입니다. 사업주가 임금을 주지 않거나, 일부만을 주거나 약속한 지급일보다 늦게 주는 일이 반복되면, 근로자가 사업장변경을 신청할 수 있는 사유에 해당할 수 있습니다.

### ○ Цалин олгох өдөр

Ажил олгогч ажилтанд ажлын хөлсийг тооцоолон олгох өдрийг товлон хэлж өгнө. Хэрэв ажил олгогчийн зүгээс цалинг тогтоосон өдрөө өгөхгүй мөн таслан өгөх зэрэг үйлдлүүдийг удаа дараа гаргасан бол, энэ нь ажлын байраа солих шалтгаан болж болно.

### ○ 지급방법

근로계약에서 정한대로 사업주가 근로자에게 현금으로 임금을 주거나, 근로자의 통장에 임금을 입금 합니다. 임금 전액은 반드시 근로자 본인에게 지급하여야 합니다. 사업주가 근로자의 통장을 보관하거나 관리하겠다고 하는 경우에도, 근로자가 통장을 사업주에게 줄 필요도 의무도 없습니다.

### ○ Цалин олгох

Хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажлын хөлс буюу цалинг ажил олгогч ажилтанд бэлнээр болон дансаар шилжүүлэн олгоно. Цалинг 100 хувь тухайн ажилтанд өөрт нь хүлээлгэн өгөх ба хэрэв ажил олгогчийн зүгээс ажилтны хувийн данс болон хадгаламжийн дэвтрийг хадгалах санал тавибал ажилтан энэхүү саналаас татгалзах

бүрэн эрхтэй гэдгээ санууштай.

#### ○ 숙식제공

사업주가 숙박시설을 제공하거나 식사를 제공하는 경우가 있습니다. 사업주가 식사나 숙박시설을 제공하는 경우에, 근로자가 비용을 낼 것인지, 사업주가 무상으로 제공하는 것 인지는 근로계약으로 정하게 됩니다. 근로자가 식사나 숙박시설을 이용하기 위해서 돈을 내야 하는 경우에는, 보통임금에서 식사비용이나 숙박비용을 공제하고 나머지 금액을 근로자에게 지급합니다. 만약에 사업주가 제공하는 숙박시설이나 식사가 너무 비싸거나 질이 낮은 경우, 사업주에게 불만사항을 이야기하고 개선을 요구하거나, 사업주와 협의하여 숙박시설이나 식사를 이용하지 않을 수 있습니다.

#### ○ Байр хоолоор хангах

Ажил олгогчийн зүгээс байрлах байр болон хоолоор хангах тохиолдол байдаг. Энэ тохиолдолд байр болон хоолны хөлсийг ажилтан өөрөө төлөх юмуу эвсэл ажил олгогчийн зүгээс 100 хувь дааж байгаа эсэх талаар хөдөлмөрийн гэрээнд тодотгон тусгана. Хэрэв ажилтан байр, хоолны хөлсөө өөрөө төлөх тохиолдолд ихэнхдээ ажлын хөлснөөс байр хоолны мөнгийн суутган хасаж тооцдог. Мөн хэрэв ажил олгогчийн зүгээс хангаж буй байр хоолны үнэ дэндүү үнэтэй байх юмуу шаардлага хангахгүй байгаа тохиолдолд энэ талаар ажил олгогчид хэлж байдлыг сайжруулах эсвэл хангамж авахгүй байж болно.

#### ○ 사업주의 권리의 한계

외국인근로자가 자기 말을 듣지 않으면 고국으로 돌려보낸다고 협박을 하는 사업주도 있다고 합니다. 그러나 사업주가 근로계약을 해지하더라도, 근로자가 바로 고국으로 돌아가야 하는 것은 아닙니다. 사업주가 마음대로 근로자를 고국으로 보낼 수 없고, 근로자가 근로계약의 내용을 잘 지키면서 일했다면, 사업주의 협박을 걱정할 필요가 없습니다

#### ○ Ажил олгогчийн эрх ба эрхийн хязгаар

Гадаад ажилтан ажил олгогчийн саналыг дагаагүй тохиолдолд эх орон руу нь буцаана гэж айлган сүрдүүлэх тохиолдлууд гардаг. Гэвч үүнээс мэдэх ёстой хамгийн чухал зүйл нь ажил олгогч нь ажилтанг өөрийн эх нутаг руу нь буцаах эрх огт байхгүй бөгөөд ажил олгогчтой хийсэн хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан ч ажилтан шууд эх орон руугаа заавал буцах шаардлагагүй. Ажилтан гэрээнд заасны дагуу өөрийн үүргээ биелүүлэн ажилласан бол энэ тал дээр санаа зовох нь илүүц хэрэг юм.

#### ④ <표준근로계약서>작성 시 유의사항

표준근로계약서를 작성함에 있어서 아래와 같은 사항에 유의할 필요가 있습니다.

- 사용자의 소재지와 업체명을 정확히 확인합니다.
- 근로계약기간은 희망하는 기간을 정확히 기재합니다. 수습계약기간은 업무의 익숙도, 적응력등을 고려하여 실무능력을 배우는 기간입니다. 이 기간동안은 임금의 일부가 감액될 수 있으므로

로 이 기간이 어떻게 정해져 있는지 정확히 확인하고 계약을 체결하여야 합니다.

- 업무내용은 근로자가 실제로 하여야 할 업무의 내용입니다. 자신이 희망하거나 할 수 있는 업무의 내용에 해당하는지, 해당 업무의 위험도가 어떠한 지 확인해야 합니다.
- 농림, 축산, 양잠, 수산사업의 경우 근로 및 휴게시간은 근로기준법의 기준에 따르지 않을 수 있습니다. 따라서 사용주와의 계약조건에 따라 근로 및 휴게시간이 정해지므로 적절한 근로시간이 설정되고 휴게시간이 보장되는지 확인해야 합니다.
- 임금은 직접 현금으로 지급받거나 통장으로 입금을 받을 수 있습니다. 임금을 지급 받았음을 명확히 확인하기 위하여는 통장으로 입금을 받는 것이 바람직하며, 통장과 도장 등은 사용주가 이를 보관할 권리가 없으므로 반드시 근로자 본인이 보관하도록 합니다.
- 숙박시설 및 식사제공과 관련하여서는 사업주와 근로자간 협의로 정하도록 합니다. 근로자의 경우 숙박시설과 식사제공이 어떠한 형태로 제공되는지 사전에 알 수 없는 경우가 많으므로 필요한 경우 업무처리기관을 통하여 사전에 필요한 정보를 요청해보도록 합니다. 또한 이에 대해 근로자부담금액을 협의하여 정할 수 있는데 숙박시설 및 식사제공이 근로자가 제공한 금액에 현저히 미치지 못하는 경우에는 외국인근로자를 지원하는 기관과 상담하여 해당조건을 변경할 수 있는지 협의하는 것이 바람직합니다.
- 기타 사업주와 표준계약서에 포함되어 있지 않은 사항에 대하여 별도로 특약을 정하는 경우 근로자에게 일방적으로 부담을 주는 내용이 없는지 사전에 반드시 확인하여야 합니다.

#### ④<Хөдөлмөрийн гэрээ>-г хийхдээ анхаарах зүйлс

Хөдөлмөрийн гэрээг хийхдээ дараах зүйс дээр анхаарах шаардлагатай.

- Ajил олгогч байгууллагын нэр болон байрлалыг зөв тодорхой мэдэж байх.
- Хөдөлмөрийн гэрээний хүчинтэй хугацааг өөрийн саналын дагуу тавих. Дадлагын хугацаа гэдэг нь ажилтан уг ажилд дасан зохицох болон ажлын арга барилд суралцах хугацааг хэлнэ. Энэ хугацаанд цалингаас тодорхой хувийг суутган олгох нь хууль бус үйлдэл биш бөгөөд гол нь дадлагын хугацааг хэзээнээс хэзээ хүртэл гэдгийг сайтар шалгасны дараа гэрээг хийнэ.
- Ажлын агууламж гэдэг нь ажилтны хариуцан ажиллах ажил чухам ямар ажил болохыг тодорхойлсон заалт бөгөөд гэрээг байгуулахдаа өөрийн хариуцан ажиллах ажил ямар ажил болох мөн ажлын аюулгүй байдлыг нягтлан шалгана.
- Хөдөө аж ахуй, Мал аж ахуй, далай, усны аж ахуйн салбарын хувьд ажлын болон амралтын цаг хуульд заасны дагуу мөрдөгдөхгүй байх тохиолдол гардаг. Энэ тохиолдолд үүнийг хөдөлмөрийн гэрээний заалтанд тодруулан тусган оруулсан эсэхийг няглан шалгана.
- Ажлын хөлсийг бэлэн мөнгөөр болон дансаар шилжүүлэн авч болно. Цалин орж ирсэн гэдгийг баримттай үлдээхийн тулд дансны аргаар шилжүүлэн авах нь хамгийн тохиромжтой болгохуүц арга бөгөөд ажилтны нэр дээрх дансыг ажилтнаас өөр хэн нэгэн(ажил олгогч) хадгалах болон эзэмших эрхгүй гэдгийг сайтар санах нь зүйтэй.
- Байр хоолоор хангуулах болон хангах асуудлыг ажилтан ажил олгогч 2 тал харилцан ярилцаж шийднэ. Ажилтан ажил олгогчийн зүгээс хангаж буй байр хоол ямар хэлбэрээр хангагдахыг урьдчилан мэдэх боломжгүй байх тохиолдлууд их гардаг бөгөөд энэ тохиолдолд “Ажил гүйцэтгэгч байгуулга”-аар дамжуулан хэрэгцээтэй мэдээллийг авч болно. Мөн байр

хоолны төлбөрөөс хэдэн хувийг ажилтаны зүгээс төлөх талаар харилцан тохирно. Хэрэв ажилтны төлсөн мөнгөн дүнтэй дүйцхүйц байр хоолоор хангахгүй байх тохиолдолд “Гадаадын ажиллах хүчээр хангах байгуулга”- аас зөвлөгөө авч уг асуудлыг өөрчлөн шийдвэрлэх арга замыг хайх нь хамгийн зүйтэй алхам юм.

- Хөдөлмөрийн гэрээнд тусгагдаагүй бусад асуудлын талаар тусгай гэрээ байгуулах тохиолдолд гэрээний агуулгад ажилтны эсрэг чиглэсэн зүйлс байгаа эсэхийг урьдчилан нягтална.

## II. 한국에서 일하면서 겪을 수 있는 문제

### II. Солонгос улсад ажиллаж амьдрах хугацаанд үүсэж болох бэрхшээлүүд

#### 1. 이럴 때는 어떻게 해야 하나요?

##### ① 사업주가 임금/퇴직금을 주지 않아요.

사업주는 근로자의 수습기간에도 임금을 주어야하며, 사업주가 수습기간이라는 이유로 임금을 주지 않으면 불법입니다. 근로자가 1년 이상 일한 경우 사업주는 임금과 별도로 퇴직금을 지급해야 합니다. 사업주가 임금/퇴직금을 주지 않으면, 일하고 있는 곳의 지방고용노동청에 임금체불로 신고해야 합니다. 고용노동청은 근로자의 신고가 있으면, 이에 대해 조사한 후에 사업주에게 임금/퇴직금을 지급하라는 명령을 합니다. 사업주가 이러한 명령에 따르지 않고 계속 임금/퇴직금을 지급하지 않으면, 형사처벌을 받을 수 있습니다.

지방고용노동청은 고용노동부의 소속기관으로 전국에 있습니다. 외국인근로자는 회사의 소재지관할지방고용노동청을 찾아가면 됩니다. 예를들어 안산시에서 일하는 근로자는 안산고용노동지청이 관할권을 가진 기관입니다. 회사 주변에 가까운 고용노동청을 찾아 방문하기 바랍니다.

고용노동청에 신고를 할 때에는 근로자에 관한 정보, 사업주에 관한 정보, 그리고 신고하고자 하는 내용을 적은 신고서를 제출하면되고, 따로 제출해야되는 서류가 있는 것은 아닙니다. 그러나 근로계약서, 임금명세서 또는 급여명세서, 임금을 지급받은 계좌의 내역과 같은 구체적인 자료는 본인이 준비하는 것이 좋습니다. 함께 일하는 동료의 증언이나 일한 시간을 알 수 있는 자료를 확보하는 것도 도움이 됩니다.

지방고용노동청이 어디인지 모르거나, 한국어를 잘모르거나, 어떻게 신고해야할지 모르겠으면, 외국인근로자지원기관이나 상담기관의 도움을 받으시기 바랍니다. 이러한 기관에서 외국인근로자 대신 신고서를 작성해 주기도 합니다.

만약에 사업주가 형사처벌을 받아도 임금을 주지 않는 경우에는 근로자가 사업주를 상대로 민사소송을 제기하여 임금을 청구할 수도 있습니다. 최근 관련법이 개정되어 판결문을 받은 체불임금

에 대해서는 최대 400만원까지 국가가 대신 지급하는 소액체당금제도도 마련되었습니다. 다만, 민사소송을 제기하여 판결을 받기까지 시간이 오래 걸리고 소송비용을 부담해야 하는 어려움이 있습니다.

## 1. Дараах тохиолдлуудад асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

### ① Ажил олгогчийн ажлын хөлс болон ажлаас гарсны тэтгэмж өгөхгүй байх тохиолдолд

Ажил олгогч ажилтны дадлагийн хугацаанд ч ажлын хөлсийг бодон өгөх үүрэгтэй ба хэрэв дадлагын хугацаа гэсэн шалтгаанаар ажлын хөлсийг олгохгүй бол энэ нь хууль бус үйлдэл болно. Ажил олгогч уг ажилд 1 жилээс дээш хугацаар ажилласан бол цалингаас гадна “Ажлаас халагдсаны тэтгэмж” ийг нэмэлтээр тооцон олгох үүрэгтэй. Ажил олгогч ажлын хөлсийг тогтоосон хугацаанд олгохгүй бол өөрийн амьдарч буй нутаг дэвсгэрийн “Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс” дээр очин энэ талаар мэдэгдэл хийнэ. “Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс” нь ажилтны өгсөн мэдэгдлийн дагуу шалгалт хийн ажил олгогчид ажлын хөлсийг журмын дагуу өгөхийг үүрэг болгоно. Тус хэлтэс нь Ажил олгогчийн зүгээс энэхүү үүргийг биелүүлээгүй тохиолдолд эрүүгийн хуулийн дагуу шийтгэл хүлээлгэх эрх бүхий байгуулга юм.

“Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс” –т хандахдаа ажилтан өөрийнхөө талаар үндсэн мэдээлэл, ажил олгогчтой холбоотой мэдээллийг мэдэгдэл хийх болсон шалтгаанаа бичсэн өрөгдлийн хамт өгөх ба энд дурьдснаас өөр ямар нэг бичиг баримт шаардлагагүй болно. Ингэхдээ байгуулсан хөдөлмөрийн гэрээ, цалингийн тайлан бичиг, цалин авч байсан дансны гүйлгээ зэрэг нарийн мэдээллүүдтэй холбоотой баримт бичгийг хувь хүн өөрөө бэлдэх нь зүйтэй. Мөн үүнээс гадна хамт ажилладаг ажилтангууд болон бодит байдлыг гэрчлэх хүн, ажилласан гэдгийг батлах баримт бичгийг бэлтгэх нь зүйтэй.

“Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс” –ийн байрлалыг мэдэхгүй болон хэлний бэрхшээлтэй бол “Гадаад ажилтныг дэмжих төв” болон бусад зөвлөгөө өгөх байгууллагаас тусламж хүсэх боломжтой. Эдгээр байгууллагаудаас гадаад ажилтны өмнөөс уг гомдлын мэдэгдлийг мэдүүлэх боломжтой байдаг.

Хэрэв ажил олгогч эрүүгийн хуулийн дагуу шийтгэл амссан ч цалинг олгохгүй байх тохиолдолд ажилтан ажил олгогчийг “Иргэний эрхийн хууль” –ийн дагуу зарга үүсгэж цалингаа нэхэмжилж болно. Сүүлийн жилүүдэд энэ тухай хууль өөрчлөгдсөнтэйгээр холбоотой хэрэг таслан шийвэрлэгдсэн тохиолдолд улсаас дээд тал нь 4 сая вон хүртэлх хэмжээний мөнгөн дунг төлөөлөн олгох тухай заалт тусгагдсан. Гэвч эндээс үүсэх бэршээлтэй талын нэг нь хэрэг таслан шийдэгдэх хугацаа уртсах болон заргатай холбоотой санхүүгийн асуудлыг ажилтан өөрийн зүгээс хариуцах явдал юм.

### ② 소액체당금제도는 어떻게 이용 할 수 있나요?

Q. 누가 지급 받을 수 있나요?

A. ①이전회사가 퇴직일 당시 상시 근로자 수 1명 이상을 고용하여 6개월 이상 가동이 되었고, ② 퇴직한 다음날부터 2년 이내에 법원에 소송을 제기하였으며, ③위 소송에서 승소 확정판결을 받은 경우에 지급대상에 해당합니다.

\*건설업 무면허 하수급인(이른바 십장)에게 고용되었던 경우에는 무면허 하수급인에게 도급을 준 직상의 건설업자도 회사로 봅니다.

**Q. 어떻게 하면 받을 수 있나요?**

A. 첫째로, 고용노동부에 신고하는 방법이 있습니다. 이를 통해서 해결되지 않는 경우 체불금품확인서를 발급 받으신 후 대한법률구조공단에 무료법률지원신청을 할 수 있습니다. 이 소송에서 승소할 경우 소액체당금지급청구서\*를 근로복지공단에 제출하면 본인의 계좌로 입금받을 수 있습니다.

\*판결문, 확정증명원, 체불금품확인서 사본을 첨부하여 확정판결일부터 1년 이내에 제출하여야 합니다.

**Q. 무료 법률지원은 어떻게 신청할 수 있나요?**

A. 무료 법률지원을 받는 방법은 아래 주소지 관할 대한법률구조공단 사무소를 방문하여야 합니다(선택 가능).

① 근로자의 외국인 등록지

② 사업자 주소지

-법인: 법인의 주된 사무소(본점) 또는 영업소가 있는 곳

-개인: 사업주의 주민등록상 주소지 또는 사무소·영업소가 있는 곳

대한법률구조공단 사무소를 방문하실 때 구비하셔야 하는 서류는 아래와 같습니다.

① 공통: 체불금품확인서, 외국인등록등본(또는 초본) 1부, 신분증, 막도장(소송기간 동안 공단에 맡길 수 있는 도장, 인감도장 아님.)

② 사업주가 법인인 경우: 법인등기부등본2부

법인등기부등본, 부동산등기부등본은 대한민국법원 인터넷등기소에서 발급용으로 발급 가능합니다.

기타 문의가 필요하시다면 국번없이 132번으로 전화주시거나, [www.klac.or.kr](http://www.klac.or.kr)로 방문하시기 바랍니다.

**Q. 400만원을 초과한 임금은 어떻게 받을 수 있나요?**

A. 400만원을 초과하는 임금의 경우 사업주에게 받아야 하므로 소송 제기와 동시에 사업주의 재산을 가압류하는 것이 바람직합니다. 여기서 가압류란 소송판결이 확정되기 전에 재산을 처분할 수 없도록 하는 조치를 의미합니다.

사업주의 부동산, 자동차, 채권, 유체동산을 가압류하기 위해 필요한 서류는 아래와 같습니다.

- ① 부동산 가압류: 부동산등기부등본(토지, 건물) 각1부.
- ② 자동차 가압류: 자동차등록원부1부
- ③ 채권가압류\*(예금, 임대차보증금, 공사대금등):
  - ④ 사업주 주소지(또는영업장소) 부동산등기부등본1부
  - ⑤ 제3채무자\*에 대한 아래 서류등
    - 제3채무자가 개인인 경우: 인적사항 및 가압류 할 채권의 내용
    - 제3채무자가 법인인 경우: 법인등기부등본 1부 및 가압류 할 채권의 내용

\*채권가압류란? 사업주가 제3채무자에게 갖고 있는 채권을 보전하는 조치입니다. 통상 사업주가 제3채무자에게 갖고 있는 예금채권, 임대차보증금채권, 물품 또는 용역대금채권, 카드결제대금등을 대상으로 합니다. 채권가압류가 된 경우에는 제3채무자는 사업주에게 대금 등을 지급하지 못하게 되고, 승소 판결을 얻은 근로자가 제3채무자에게 그 대금의 지급을 요구(=추심)할 수 있습니다.

\*채권가압류에서 제3채무자란? 사업주의 채무를 진 제3자를 말합니다. 사업주의 예금채권은 은행, 임대차보증금은 임대인, 물품 또는 용역대금은 물품을 구매한 자 또는 용역을 발주한 자, 카드결제대금은 카드회사를 제3채무자라고합니다.

## ② Авч чадаагүй цалингаа авахын тулд “Төрөөс төлөөлөн олгох” хөтөлбөрт хэрхэн хамрагдах вэ?

Асуулт: Ямар тохиолдуудад энэхүү хөтөлбөрт хамрагдах боломжтой вэ?

Хариулт. ①Урьд өмнө нь ажиллаж байсан байгууллага нь тус байгууллагаас гарах үед 1-ээс илүү ажилтантай, 6 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулсан болон ②Ажилаас гарснаас хойш 2 жилийн дотор хуулийн байгууллагатай зарга үүсгэн өргөдөл гомдол мэдүүлсэн тохиололд. ③Хуулийн байгууллага энэхүү заргын дагуу хянаж үзэж заргад ялсан тохиолдолд энэхүү хөтөлбөрт хамрагдах боломжтой.

\* Барилга угсралтын талбайд тусгай ажлын сертификатгүй ажилтан(барилгын туслах ажилтан) –аар орж цалинг ажлын гүйцэтгэлийн дараа өгөхөөр болсон тохиолдолд ажил олгогч байгуулгыг барилгын компанийн хэлбэрт тооцох болно.

Асуулт: Хэрхэн яаж хамрагдах вэ?

Хариулт: Нэгдүгээрт, Хөдөлмөрийн яаманд мэдүүлэх боломжтой. Ингэснээр цалингаа авч чадаагүй нь үнэн болохыг баталсан баримтыг ажилтанд олгоно. Үүний дараа “Улсын хуулийн туслалцаа үзүүлэх байгуулга”- аар дамжуулан үнэ төлбөргүйгээр хууль эрх зүйн зөвлөгөө туслалцаа авах тухай хүсэлт гаргаж болно. Энэ зарга хүчинтэйд тооцогдон заргаа авсан тохиолдолд “Төрөөс төлөөлөн олгох хөтөлбөрт” хамрагдах хүсэлтийн маягтыг холбогдох Хөдөлмөр, хalamжийн байгуулгад мэдүүлснээр өөрийн нэр дээрх дансаар уг мөнгөн дүн шилжигдэнэ.

\* Зарга шийдэгдсэн тухай шийдвэрийн хуудас, тодорхойлсон баримт, цалингаа авч чадаагүй үнэн болохыг батлах бичиг зэргийг зарга шийдэгдснээс хойш 1 жилийн дотор холбогдох Хөдөлмөр, халамжийн байгуулгад мэдүүлсэн байна.

**Асуулт:** Үнэ төлбөргүй хууль эрх зүйн туслалцаа авах тухай хэрхэн мэдэгдэх вэ?

**Хариулт:**Өөрийн хаягийн дагуу харьялагдах “Улсын хуулийн туслалцаа олгох байгууллага”-т өөрийн биеэр очих ёстой. (сонгох боломжтой)

①Ажилтан өөрийн гадаад иргэний үнэмлэх

②Ажил олгогчийн хаяг

-Улсын бүртгэлтэй хуулийн этгээд: Хуулийн этгээдийн голлон үйл ажиллагаа явуулдаг объект

- Улсын бүртгэлгүй хувь хүн: Ажил олгогчийн иргэний бүртгэл(иргэний үнэмлэх)-ийн хаяг эсвэл төв оффис

Улсын хуулийн байгууллагад өөрийн биеэр очихдоо дараах бичиг баримтыг бэлдэх шаардлагатай.

①Нийтлэг бичиг баримт: Цалин олгогдоогүй нь үнэн болохыг баталсан баримт, гадаад иргэний үнэмлэх(эсвэл гадаад иргэдийн бүртгэлийн ерөнхий тэмдэглэл) өөрийн тамга(заргын хугацаанд уг байгуулгад хадгалуулах тамга. Албан ёсны хэрэглээний тамга биш байж болно)

②Ажил олгогч улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх тохиолдолд: Хуулийн этгээдийн улсад бүртгэгдсэн байдлын тодорхойлолт 2 хувь

Хуулийн этгээдийн улсад бүртгэгдсэн байдлыг тодорхойлолт, үл хөдлөх хөрөнгийн талаарх улсын бүртгэлийг тодорхойлолтыг Улсын Бүртгэлийн Газрын цахим хуудаснаас авах боломжтой. Бусад зүйлийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл утасаар 132 дугаарлуу холбогдож болох бөгөөд, [www.klac.or.kr](http://www.klac.or.kr)сайтаас мэдээлэл авах боломжтой.

**Асуулт: 4 сая воноос илүү хэмжээний цалинг нөхөн авах боломжтой юу?**

**Хариулт:** 4 саяаас дээш хэмжээний мөнгөн дүнг ажил олгогчоос авах ёстой ба зарга үүсгэх явцдаа эхний ээжлиинд ажил олгогчийн хөрөнгийг хураан авсан байх нь зүйтэй. Үүнд анхаарах зүйл нь ажил олгогчийн эд хөрөнгийг хураан авах тухай хуулийн шийдвэр батлагдан гарахаас өмнө уг хөрөнгийг өөрийн дураар захиран зарцуулахыг хориглоно.

Ажил олгогчийн үл хөдлөх хөрөнгө, машин, бонд, биет хувийн өмч зэргийг хураан авахад дараах бичиг баримтыг бэлдсэн байх шаардлагатай.

①Үл хөдлөх хөрөнгө: Үл хөдлөх хөрөнгийн улсад бүртгэгдсэн тухай тодорхойлолт(газар, барилга) тус бүр 1 хувь.

②Машин: Машины улсын бүртгэлийн тодорхойлолт 1 хувь.

③ Бонд: Хадгаламж, зээлийн барьцааны мөнгө, үйл ажиллагаа явуулах зардал хөрөнгө гэх мэт

А. Ажил олгогчийн хаяг, эсвэл үйл ажиллагаа явуулж буй албан газар объектын хаяг, улсын бүртгэлийн тодорхойлолт 1хувь

Б. 3 дагч зээлдэгч этгээдийн талаарх доорх бичиг баримт

- 3 дагч зээлдэгч этгээд нь хувь хүн байх тохиолдолд: Хувь хүний талаарх мэдээлэл болон хураан авч буй бондийн талаарх мэдээлэл

- 3 дагч зээлдэгч этгээд хуулийн этгээд байх тохиолдол: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн

тодорхойлолт 1 хувь, хураан авах бондын талаарх мэдээлэл

\* Бондыг хураан авах гэдэг нь: Ажил олгогч 3 дагч зээлдэгч этгээд буюу 3 дагч этгээдээс авах өр зээлтэй байх тохиолдлыг хэлж байгаа бөгөөд ингэхдээ зээлдэгч этгээдийн хадгаламжаас авах авалга, зээлийн барьцааны мөнгө, эд зүйлс болон үйлчилгээний төлбөр, картны төлбөрийн авалга гэх мэтийг хамруулан үзнэ. Бондыг битүүмжлэн хураан авах тухай хуулийн шийдвэр гарсан тохиолдолд 3 дагч зээлдэгч этгээдээс ажил олгогч өр зээлийг хүлээн авах боломжгүй болох ба энэ тохиолдолд заргад ялсан ажилтан 3 дагч зээлдэгч этгээдээс өөрийн авах ёстой мөнгөн дүнгээ гаргуулан авна.

\* Бондыг хураан авахад 3 дагч зээлдэгч этгээд гэж хэн бэ? Ажил олгогчид өр зээлтэй 3 дагч этгээдийг хэлж байгаа бөгөөд ажил олгогчийн хадгаламжаас авах авалга нь банк, түрээсийн барьцааны мөнгө нь түрээслэгч, эд зүйлс болон үйлчилгээний төлбөр нь эд хөрөнгө болон худалдаа хийхээр захиалга өгсөн захиалагч, картны төлбөрийн авалга нь картны компанийг хамруулан хэлж байгаа болно.

### ③ 근로계약서에 정한 시간보다 더 많이 일을 시켜요.

근로계약서에서 정한 것보다 일을 너무 많이 시키거나, 연장근로를 과다하게 시키는 경우에도 임금을 주지 않는 경우와 마찬가지로 지방고용노동청에 신고하여 조사해줄 것을 요청할 수 있습니다. 사업주가 근로계약을 지키지 않아서 현재의 직장에서 일을 계속할 수 없는 정도인 경우에는 “사업장변경신청”을 통해서 새로운 일자리를 찾는 방법도 있습니다. (자세한 내용은 아래의 “3. 사업장변경” 부분을 읽어보기 바랍니다.)

외국인근로자가 고용센터에 “사업장변경신청”을 하면, 고용센터는 사업주가 근로계약을 위반했는지 판단하기 위해서 지방고용노동청에 신고된 것이 있는지 확인하게 됩니다. 따라서, 사업주가 심각하게 근로계약을 위반하고 있다고 생각하는 외국인근로자는 나중에 “사업장변경신청”을 할 경우에 대비하여 지방고용노동청에 사업주의 계약위반사실을 신고하는 것이 필요합니다.

### ③Хөдөлмөрийн гэрээнд заасан цагаас илүү цагаар ажиллуулах тохиолдолд

Хөдөлмөрийн гэрээнд заасан ажлын цагаас хэт давсан цагаар үргэжлүүлэн ажиллуулсан ажлын хөлсийг өгөхгүй байх тохиодолд харьялагдах орон нутгийн “Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан хэлтэс”-т мэдэгдэн шалгуулж болно. Ажил олгогч гэрээнд заасан заалтыг зөрчсний улмаас уг ажилд цаашид ажиллахад бэрхшээлтэй байгаа тохиолдолд энхүү “Ажлын байр солих тухай мэдэгдэл”-ийг хийж өөр ажлын байр хайх боломжтой.(Үүнтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэлийг 3. “Ажлын байраа солих” хэсгийг уншина уу).

Гадаад ажилтан Хөдөлмөр эрхлэлтийн төвд “Ажлын байр солих” талаар мэдэгдэл хийвэл уг төвөөс ажил олгогч хөдөлмөрийн гэрээг зөрчсөн эсэхийг шалгахын тулд “Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан хэлтэс”-т мэдэгдэл ирсэн эсэхийг шалгана. Тиймээс ажил олгогч гэрээнд зааснаас хэт илүү цагаар ажиллуулсан тохиолдолд цаашид ажлын байраа солих магадлалтай тул харьялагдах хэсгийн “Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг хариуцсан хэлтэс”-т энэ талаар мэдэгдлийг хийх нь зүйтэй.

#### **④ 여권과 외국인등록증을 사업자가 보관하겠다고 해요.**

사업주가 외국인근로자의 여권이나 외국인등록증을 보관하고 외국인근로자에게 신분증을 돌려주지 않는 것은 불법이고, 이러한 사업주는 한국의 출입국관리법에 따라 형사처벌을 받을 수 있습니다.

외국인근로자의 여권이나 외국인등록증을 사업주가 보관하고 있는 경우에는 사업주에게 요청하여 여권이나 외국인등록증을 돌려받기 바랍니다. 만일 사업주가 돌려주지 않는 경우에는 외국인근로자를 지원하는 기관의 도움을 받아 반환을 요청할 수 있고, 경찰에 신고할 수도 있습니다.

#### **④ Ажилтны гадаад паспорт болон гадаад иргэний үнэмлэхийг ажил олгогчийн зүгээс хадгалах санал тавьсан тохиолдолд**

Ажил олгогчийн зүгээс ажилтны гадаад паспорт эсвэл гадаад иргэний үнэмлэхийг хадгалж ажилтанд буцаан олгохгүй байх нь хууль бус үйлдэл бөгөөд ингэсэн тохиолдолд ажил олгогчийг “Гадаад иргэдийн улсын хилээр нэвтрэх тухай хууль”-ийн дагуу хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

Хэрэв ажилтны гадаад паспорт, гадаад иргэний үнэмлэхийг ажил олгогч нэгэнт хадгалан авсан тохиолдолд ажил олгогчид өөрийн хүсэлтээ тавьж хадгалуулсан бичиг баримтаа хүлээн авах нь зүйтэй. Хэрэв хүсэлт гаргасан ч ажил олгогчийн зүгээс буцаан олгоогүй тохиолдолд “Гадаад ажилтныг дэмжих төв”-өөр дамжуулан энэ талаар шаардлага явуулж болох ба мөн цагдаад мэдуулж болно.

#### **⑤ 일을 하다가 다쳤어요. 산재 신청은 어떻게 하나요?**

외국인근로자가 일을 하다가 사고가 발생한 경우, 우선 응급조치를 하고 병원으로 가서 치료를 받아야 합니다. 그리고 산업재해보상보험에 따라 보상을 받기 위해서 보통 병원에 비치된 “요양 급여신청서”를 작성하여 사업장을 관할하는 근로복지공단에 제출해야 합니다. 신청서에는 사업주와 근로자가 서명해야 하는데, 사업주가 서명해 주지 않는 경우에는 서명을 거부하는 이유를 구체적으로 기재하면 사업주의 서명 없이도 근로자가 직접 신청할 수 있습니다.

근로복지공단에서는 발생한 사고가 산업재해가 맞는지 확인한 후에, 7일 이내에 산업재해로 인정하는지 여부를 근로자에게 알려줍니다. 사고와 관련된 사실관계를 확인하는데 시간이 더 걸릴 경우, 이 기간이 늘어날 수 있습니다. 근로복지공단이 발생한 사고를 산업재해로 인정하면, 근로복지공단이 근로자의 치료에 든 병원비를 병원에 대신 지급하여 주고, 사고로 인하여 일하지 못한 기간의 휴업급여도 지급합니다.

##### **[행동순서]**

병원에서 치료 → “요양급여신청서” 제출 → 근로복지공단에서 산업재해로 인정하는지 근로자에게 통지 → 근로복지공단이 병원비를 병원에 지급 → 휴업급여는 근로자에게 개별지급

이때 근로자나 그 동료들은 사고가 발생한 시간이나, 사고발생이유, 현장의 상황을 잘 기록하거나 녹음하고, 사진을 찍어놓고, 목격한 사람의 진술을 서면으로 받아놓아야 합니다. “요양급여신청서”를 제출할 때에 이러한 증거자료를 함께 제출해야 하기 때문입니다.

산업재해로 인정되면 치료비를 지급받을 수 있을 뿐 아니라, 근로자가 산업재해로 인한 부상 등으로 일하지 못한 기간에 대하여 임금의 70%에 해당하는 금액을 받을 수 있습니다. 이것을 “휴업급여”라고 합니다. “휴업급여”를 받기 위해서는 관할근로복지공단에 “휴업급여청구서”를 제출하여야 합니다. 그밖에도 치유는 되었지만 몸에 장해가 생긴 경우, 간병인이 필요한 경우 등에도 보상을 받을 수 있습니다.

신청절차를 잘 모르거나 도움이 필요한 경우에는, 반드시 주변의 외국인근로자에게 상담을 제공하는 기관이나 조직을 찾아 상담을 받으시기 바랍니다.

## **⑤Ажил хийх явцдаа бэртэж гэмтсэн тохиолдолд “Аж үйлдвэрлэл, ослын даатгал” -д хэрхэн хамрагдах вэ?**

Ажилтан ажлын байран дээрээ ажлаа хийх явцдаа бэртэж гэмтсэн тохиолдолд нэн яаралтай анхан шатны тусlamж үзүүлэх болон эмнэлэгт үзүүлнэ. Үүний дараа ослын даатгалын журмын дагуу гэмтэлтэй холбоотой нөхөн төлбөрөө авахын тулд эмнэлгийн “Эмчилгээний төлбөрийн мэдэгдэл хуудас”-ийг бөглөж ажил олгогч буюу тус байгууллагыг захиран хянах “Хөдөлмөр, халамжийн газар”-т өгнө. Уг хуудсанд ажил олгогч болон ажилтан хоёр тал гарын үсгээ зурах ёстой боловч хэрэв ажил олгогч гарны үсгээ зурахаас татгалзвал татгалзсан шалтгааныг дэлгэрэнгүй тусган бичсэнийхээ дараа нэг талын буюу өөрийн гарын үсэгтэйгээр мэдүүлж болно.

“Хөдөлмөр, халамжийн газар” -аас уг осол аж үйлдвэрлэлийн гаралтай осол мөн эсэхийг шалгаснаас 7 хоногийн дараа энэ талаарх хариуг ирүүлнэ. Осол гэмтлийн үнэн бодит байдалтай холбоотой шалгалтын явц удааширч болох бөгөөд хэрэв “Хөдөлмөр, халамжийн газар”-аас ослыг аж үйлдвэрлийн осол мөн болохыг баталвал эмчилгээний холбоотой эмнэлгийн зардлыг “Хөдөлмөр, халамжийн газар”-аас төлөх ба мөн ослын улмаас ажиллах боломжгүй хугацааны туршид цалинг тооцон олгоно.

### [Хийх зүйлсийн дараалал]

Эмнэлэгт эмчилгээ хийлгэх ->“Эмчилгээний төлбөрийн мэдэгдэл хуудас”-ийг бөглөж мэдэгдэх ->“Хөдөлмөр, халамжийн газар”-аас аж үйлдвэрлийн гаралтай осол мөн эсэх талаар хариуг ажилтанд мэдэгдэх ->“Хөдөлмөр, халамжийн газар”-ийн зүгээс эмнэлгийн төлбөрийг төлнө ->Өвчтэй байх хугацааны цалинг ажилтанд олгоно.

Ингэхдээ ажилтан болон хамт ажилагсад нь осол гарсан цаг минут, шалтгаан, осол гарсан үеийн байдлыг сайтар тэмдэглэн үлдээх юмуу дуу хураагуурт хураах мөн зурган материал зэргийг хавсруулан гэрчийн мэдүүлэг авсан байх нь чухал. Учир нь эдгээр баримтыг “Эмчилгээний төлбөрийн мэдэгдэл хуудас”-ийг цааш уламжлан мэдүүлэхдээ хавсарган өгөх шаардлагатай байдаг болно.

Аж үйлдвэрлэл, ослын даатгал мөн болох нь тогтоогдсон тохиолдолд дээр дурьдсанчлан эмчилгээний зардлаас гадна өвчтэй байх хугацаандаа үндсэн цалингийнхaa 70 хувийг авна. Цалингийн нөхөн олговрыг авахын тулд харьяалагдах “Хөдөлмөр, халамжийн газар” таа “Өвчтэй байх хугацааны цалин олголт”-ын хуудсыг бөглөж өгнө. Үүнээс гадна эмчилгээ хийсний дараа ч ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдол болон асрагч хэрэгтэй болсон тохиолдлуудад үүнтэй холбоотой төлбөрийг гаргуулан авч болно.

Мэдэгдлийг хэрхэн хийж хаана хандахаа мэдэхгүй байх тохиолдолд ойролцоо гадаад ажилтанд зөвлөгөө өгөх байгууллагуудын зөвлөгөөг зайлшигүй авахыг сануулж байна.

#### ▲ 이주민 상담기관 안내

위에서 언급한 문제 외에도 외국인 근로자가 한국에서 일하면서 여러가지 어려움을 겪을 수 있습니다. 혼자서 해결하기 어려운 문제가 생긴 때에는 적극적으로 주변에 도움을 요청하기 바랍니다. 특히 사업주와 협의하여 문제를 해결할 수 없는 경우에는 주변에 외국인 근로자에게 법률상담을 제공하는 기관이나 조직이 있는지 찾아보고 도움을 받으시기 바랍니다. 외국인근로자가 많은 지역일수록 상담을 받거나 도움을 청할 수 있는 기관(NGO 포함)들이 여러 곳 있습니다. 모국어로 전화 상담을 받을 수 있는 곳도 있습니다.

#### 이주민무료법률상담 NGO

- 이주민센터 친구 ☎ 02-6406-7179  
서울 영등포구 도림로 127, 3층 (지하철 2호선 대림역 8번출구)

서울에 있는 한국외국인력지원센터에서는 외국인근로자들이 모국어로 전화 상담을 받을 수 있습니다. 캄보디아어로 전화상담을 받기 위해서는 1644-0644를 누른 후 11을 누르면 되며(1644-0644 +11), 미얀마어로 전화 상담을 받기 위해서는 마찬가지로 1644-0644를 누른 후 13을 누르면 됩니다(1644-0644 +13). 또한 영어 홈페이지도 운영하고 있으니 궁금한 점이 있으면 <http://www.migrantok.org> 를 참고하시기 바랍니다. 한국외국인력지원센터는 의정부, 김해, 창원, 대구, 인천, 천안에 있습니다. 가까운 곳의 도움을 받으시기 바랍니다.

안산시의 경우 외국인력상담센터(HUG Korea)에 직접 방문하여 상담을 받을 수 있고, 웹사이트를 통하여 상담하거나([www.hugkorea.or.kr](http://www.hugkorea.or.kr)) 전화상담도 가능합니다. 캄보디아어 전화안내는 1577-0071을 누른 후 11과 별표를 누르면 되며(1577-0071 + 11 +\*), 미얀마어 전화상담은 마찬가지로 1577-0071을 누른 후 15와 별표를 누르면 되고(1577-0071 + 15 +\*), 베트남어 전화상담은 1577-0071을 누른 후 6과 별표(1577-0071 + 3 +\*), 몽골어 전화상담은 1577-0071을 누른 후 14와 별표를 누르면 됩니다(1577-0071 + 9 +\*).

### ▲ Гадаад иргэдэд зөвөлгөө өгөх байгуулга

Дээр дурдсан бэрхшээлүүдээс өөр олон олон бэрхшээлүүд гадаад иргэдэд тохиолдохыг үгүйсгэх аргагүй. Хэрэв асуудлыг ганцаар шийдвэрлэж чадахгүй, боломжгүй байх аваас эргэн тойрныхноосоо туслалцаа хүсэх нь хамгийн зөв алхам юм. Ялангуяа ажил олгогчтой үл ойлгоцол үүсэн энэ талаар хэрхэн яаж шийдвэрлэхээ мэдэхгүй байгаа бол гадаад иргэдэд хуулийн зөвөлгөө, туслалцаа үзүүлдэг байгууллагууд байгаа эсэхийг судлан тусламж дэмжлэг авах хэрэгтэй. Тухайн газар нутагт гадаад ажилчид ихээр төвлөрсөн байх тусмаа энэ талаар зөвөлгөө өгөх байгууллагууд болон төрийн бус байгууллагууд ихээр төвлөрсөн байдаг. Мөн хэлний бэрхшээлтэй байх тохиолдолд өөрийн төрөлх хэл дээр зөвөлгөө өгөх үйлчилгээг тус байгууллагууд давхар үзүүлдэг.

○ Гадаад иргэдийн төв ☎ 02-6406-7179

Сөүл хот, Ёндынпу дүүрэг, Дурим ду 127, 3 давхар (Метроны 2 шугам Дэрийн буудлын 8 дугаар гарц)

Сөүл хотод байрлах “Гадаадын ажиллах хүчнийг дэмжих төв”-үүдэд өөрийн эх хэл дээрээ зөвөлгөө авах боломжтой. Камбуди хэлээр зөвөлгөө авах бол 1644-0644 залган холбогдсныхоо дараа 11 дугаарт холбогдон авах боломжтой. (1644-0644+11), Миамма хэлээр зөвөлгөө авах бол дээрх дугаарт залган 13 дугаарыг дараход болно. (1644-0644+13). Мөн англи хэл дээрх цахим хуудастай бөгөөд эндээс та өөрийн хүссэн мэдээлэлээ авах боломжтой. <http://www.migrantok.org>. “Гадаадын ажиллах хүчнийг дэмжих төв” нь Өжинбү, Кимхэ, Дэгү, Инчеон, Чон ань зэрэг газруудад бий тул өөрт ойрхон газраас өөртөө хэрэгтэй үйчилгээг авах боломжтой.

Хэрэв та Ансан хотод байдаг бол “Гадаадын ажиллах хүчнийг дэмжих төв”-д өөрийн биеэр очин зөвөлгөө авах боломжтой ба мөн цахим хуудас, утсаар ч зөвөлгөө авч болно. Камбуди хэлээр зөвөлгөө авах бол 1577-0071 залган холбогдсныхоо дараа 11 дугаарыг даран од товчлуурыг даран авах боломжтой. (1577-0071+11\*), Миамма хэлээр зөвөлгөө авах бол дээрх дугаарт залган 15 дугаарыг дараход болно. (1577-0071+15\*) дугаарт, Виетнам хэлээр авах бол дээрх мөн адил дээрх дугаарт залган 6 дугаарыг даран од товчлуурыг дарах(1577-0071+6\*) ба Монгол хэлээр зөвөлгөө авах бол 14 даран од товчлуурыг даран (1577-0071+14\*) зөвөлгөө авах боломжтой.

### ⑥ 한국에 온 유학생이 구직을 하려면 어떻게 해야 하나요?

한국에 온 유학생이 구직활동\*을 하고자 하는 경우, 유학 비자(D2)에서 구직 비자(D10)로 변경하여야 합니다. 그 요건과 절차는 아래와 같습니다.

\*구직활동이란 국내 기업·단체 등에서 행하는 구직활동 뿐만 아니라 정식 취업 전에 연수비를 받고 행하는 단기 인턴과정을 포함합니다.

가. 허용대상

- ① 국내 전문대학에서 전문학사 학위를 취득(예정자 포함)한 유학생
- ② 국내 대학에서 학사 이상의 학위를 취득(예정자 포함)하거나 학술연구기관 등의 연구과정을 수료(예정자 포함)한 유학생
- ③ 교수(E-1)부터 특정활동(E-7)\*까지의 자격으로 계속하여 취업을 희망하지만 체류기간만료일 이전에 고용계약갱신 또는 다른 근무처를 구하지 못한 자  
\*단 예술통행(E-6)자격의 경우 유통업소 등 공연자(E-6-2)는 적용대상에서 제외
- ④ 국내·외 학사이상의 학위(학위 수여예정자 포함)를 소지하고 지식재산권이나 이에 준하는 기술력을 바탕으로 창업 준비를 하려는 자
- ⑤ 기타 非 구직자격 소지자(체류자격 B-1, B-2포함)로서 구직(D-10)사증 발급 대상자 요건을 갖춘 합법체류 외국인

나. 제한대상

최근1년 이내 고용계약기간 중 고용주 귀책사유 없이 임의로 퇴직한 후 구직(D-10)자격으로 변경허가

를 받은 사실이 있는 자

다. 제출서류

- ① 신청서, 여권 및 외국인등록증, 수수료
- ② 학력증명서 또는 성적증명서\*
- \*출입국시스템으로 확인되는 경우에는 제출이 면제됩니다.
- ③ 구직활동계획서
- ④ 국가기술자격증 사본(해당자에 한함)

라. 신청요령

신분이 변동(예정 포함)되는 즉시 체류지 관할 사무소 등에 신청하여야 합니다.

## ⑥ Солонгос улсад суралцан төгссөн гадаад оюутан хэрхэн ажилд орох вэ?

Солонгос улсад ирж суралцан төгссөн гадаадын оюутан ажилд орохын тулд нэн түрүүнд оюутны D2 ангилалын визээр ажил хайх D10 визээр солих шаардлагатай. Ингэхийн тулд дараах шаардлагыг хангасан байна.

\*Ажил хайх гэдэгт дотоодын албан байгууллагад өөрийн орохыг хүссэн ажлын байраа хайхаас гадна албан ёсны ажилтан болохын өмнөх дагалдан хийх хугацааг хамруулан хэлнэ.

A. Ажил хайх эрх бүхий хүмүүс

- ①Дотоодын мэргэжлийн сургуульд баклаврын зэрэг авсан (авах нь тодорхой ба хүлээгдэж буй) оюутан
- ②Дотоодын их сургуульд баклаврын зэргээс дээш зэрэг авсан авсан (авах нь тодорхой хүлээгдэж буй) оюутан болон эрдэм шинжилгээний байгууллагад судалгааны бүхий л шатуудыг амжилттай дүүргэсэн (дүүргэх нь тодорхой ба хүлээгдэж буй) оюутан
- ③Багшлах E-1 ангиллын виз болон тусгай зөвшөөрлийн E-7 ангиллын визээр ангилаа

солиулахыг хүсэж байгаа ч оршин суух хугацаа дуусахаас өмнө хөдөлмөрийн гэрээг сунгаж чадаагүй мөн өөр ажлын байр хараахан олоогүй байгаа иргэн.

\* Жич: Соёл урлагийн чиглэлийн Е-6 ангилалын виз болон тоглолт, концертын тусгай зөвшөөрөл бүхий Е-6-2 ангилалын визтэй иргэдэд хамаарахгүй болно.

④ Гадаад болон дотоодын сургуулийн баклаврын зэрэг ба түүнээс дээш (авах нь тодорхой ба хүлээгдэж буй) зэрэгтэй болон өөрийн мэргэжлийн ур чадвараа ашиглан тухайн салбартаа өөрийн бизнесээ эхлүүлэхээр төлөвлөж буй иргэд.

⑤ Бусад ажил хайх визтэй(B-1, B-2) болон ажил хайх D-10 ангилалын визний болзлыг хангасан иргэд.

#### **Б. Виз мэдүүлэх эрх нь хязгаарлагдах тохиолдолд**

Сүүлийн нэг жилийн дотор буюу хөдөлмөрийн гэрээний хүчинтэй хугацааны дотор ажил олгогчийн харилцан зөвшилцлгүйгээр, өөрийн дураар ажлаасаа гарснаас хойш ажил хайх виз болох D-10 ангилалын визийг дахин авсан тохиолдолд

#### **В. Шаардлагатай материалууд**

① Маягт, гадаад паспорт болон гадаад иргэний үнэмлэх, шимтгэл болон хураамж

② Сургуулийн диплом эсвэл дүнгийн хуудас\*

\* Гадаад иргэдийн улсын хилээр нэвтрэх асуудал эрхэлсэн хэлтсийн дотоод системээр шалгагдан харагдаж байгаа тохиолдолд шаардлагагүй.

③ Ажил хайх төлөвлөгөө

④ Төрөл бүрийн сертификат(байгаа тохиолдолд)

#### **Г. Зарчим**

Оршин суух зорилго өөрчлөгдсөн(өөрчлөгдхөөр төлөвлөгдж байгаа) тохиолдолд харьяалагдах хэлтэст хандан энэ тухайгаа мэдүүлэх шаардлагатай.

## **2. 사업장 변경 신청하기**

외국인근로자는 한국에 들어올 때에 근로계약을 체결한 사업장에서 계속 일하는 것이 원칙입니다. 그러나 사업장에서 계속 일하는 것이 어려운 사정이 있는 때에는 사업장을 변경할 수 있습니다. 이러한 사업장변경은 법에서 정한 절차에 따르는 경우에만 가능하다는 점을 꼭 기억해야 합니다. 외국인근로자가 고용센터의 허가를 받지 않고 마음대로 사업장(근무지, 회사)을 옮길 경우, 불법체류 상태가 될 수 있습니다.

## **2. Ajlyin bairaa solih tухай мэдэгдэх**

Зарчмын дагуу бол гадаадын ажилчин солонгос улсад ирэхдээ хөдөлмөрийн гэрээ хийсэн албан байгууллагадаа тасралтгүй ажиллах ёстой байдаг. Гэвч уг ажлын байрандаа цаашид ажиллахад бэрхшээлтэй байх тохиолдолд ажлын байраа солих эрхтэй байдаг. Ингэхдээ хуулинд заасан журмын дагуу байх тохиолдолд л солих боломжтой гэдгийг санах нь зүйтэй. Энэхүү зарчим нь хэрэв гадаад ажилтан Хөдөлмөр эрхлэлтийн төвийн оролцоогүйгээр өөрийн дур мэдэн амьдарч буй орон нутаг, ажлын байраа

өөрчилсөн тохиолдолд хууль бус үйлдэлд хамаарна.

### 1) 사업장을 변경할 수 있는 사유

외국인근로자가 사업장을 변경할 수 있는 경우를 규정하는 법은 “외국인 근로자의 고용 등에 관한 법률”과 관련 규정들입니다. 이 법에서 사업장변경이 가능하다고 정하는 사유로는 아래와 같은 것들이 있습니다. 자신이 아래와 같은 사유에 해당한다고 생각하는 외국인 근로자는 주변의 상담기관을 찾아서 자신이 사업장변경을 할 수 있는 경우인지 전문가의 조언을 들어보고, 신청 절차에 따라 신청할 수 있습니다.

- 사업주가 정당한 사유로 근로계약기간 도중에 근로계약을 해지하려고 하거나, 근로계약이 만료된 후 갱신을 거절하려는 경우
- 사업주의 휴업, 폐업
- 사업주의 잘못으로 정부로부터 받은 외국인 고용허가가 취소되거나 고용이 제한되어 외국인근로자를 고용할 수 없게 된 경우
- 사업주의 사정으로 외국인근로자가 장기간 휴업이나 휴직하는 경우: 임금의 70% 미만을 받은 기간이 2개월 이상이거나, 임금의 90% 미만을 지급받은 기간이 6개월 이상인 경우 등이 여기에 해당
- 사업장의 폐업이나 도산이 확실시되는 경우: 사업장에 파산절차 등이 시작되거나, 사업이 중단되어 다시 운영되지 않는 경우
- 사업장의 인원을 줄일 필요성이 있어서 사업주로부터의 퇴직권고 등의 사유로 일을 그만두게 되는 경우
- 사업주의 근로조건 위반 때문에 외국인근로자가 더 이상 일을 하기 어렵다고 인정되는 경우: 2개월 이상의 기간 동안 임금이나 근로시간이 20%이상 낮아지거나, 근로조건이 나빠지는 경우, 일하는 시간대를 사업주가 마음대로 변경한 채로 1개월 이상 계속되는 경우 등이 해당
- 임금을 주지 않거나 늦게 주는 경우: 2개월분 이상의 임금을 받지 못하거나, 2개월 이상 임금의 30% 이상을 받지 못하거나 최저임금미만의 임금을 주는 경우, 임금을 주지 않거나 늦게 주는 일이 반복되는 경우 등이 여기에 해당
- 부당한 대우를 받은 경우: 사업주로부터 폭행, 폭언, 성희롱, 성폭력등을 당하거나, 국적, 종교, 성별, 신체적 장애 등을 이유로 불합리한 차별대우를 받은 경우가 여기에 해당
- 외국인근로자가 몸을 다쳐서 지금까지 일하던 사업장에서 일하기는 어려우나, 다른 사업장에서 일하는 것은 가능한 경우

### 1) Ажлын байраа солих боломжтой тохиолдлууд

Гадаадын иргэн ажлын байраа өөрчилж болох тохиолдлуудыг “Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль” –д журамлан заасан бөгөөд энэхүү хуульд дурьдагдсан тохиолдолдуудад ажлын байраа солих эрхтэй болно. Ажлын байраа өөрчлөхөөр төлөвлөж буй энэхүү тохиолдлуудад хамарагдах эсэхээ эхлээд тогтоосны дараа хамарагдаж байх тохиолдолд энэ талаар зөвөлгөө өгөх байгууллагыг хайж энэ талаар лавлан мөн мэргэжилтний зөвөлгөөг авсны дараа дэс дараалалын дагуу мэдүүлгээ хийхэд болно.

- Ажил олгогчийн талаас хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хөдөлмөрийн гэрээг цуцлахыг хүсэх юмуу хөдөлмөрийн гэрээний хүчинтэй хугацаа дуусгавар болоход уг гэрээг дахин сунгахаас татгалзсан тохиолдолд
- Ажил олгогч байгууллагаа болон үйл ажиллагаагаа түр зогсоох эсвэл үйл ажиллагаагаа таслан зогсоох болсон тохиолдолд
- Ажил олгогч өөрийн буруутай үйлдлийн улмаас улсаас олгогдсон гадаад иргэнийг ажиллуулах эрх нь хязгаарлагдсан тохиолдолд
- Ажил олгогчийн шалтгаанаас үүдэн хэт удаан хугацаагаар амраах тохиолдолд: Энэ тохиолдол 2 сараас дээших хугацаанд үндсэн цалингийн 70 хувиас бага авсан байх болон цалингийн 90 хувиас бага мөнгөн дүнг 6 сарын туршид авсан байх тохиолдолууд багтана.
- Ажил олгогч байгуулгын үйл ажиллагаа бүрэн зогсох нь тодорхой болсон тохиолдолд: Энэ талаарх мэдэгдлийг хийж холбогдох газруудад мэдэгдэж эхэлсэн болон үйл ажиллагаа таслан зогсоогдож дахин хуваарийн дагуу ажиллахгүй байх тохиолдод
- Ажил олгогч байгуулгын зүгээс орон тооны цомхтгол хийж, энэхүү цомхтголд хамрагдан ажлаас гарах болсон тохиолдолд
- Ажил олгогч хөдөлмөрийн нөхцлийг зөрчсний улмаас ажилтан цаашид ажиллах боломжгүй болсон тохиолдлууд: 2 сар ба түүнээс дээш хугацааны туршид ажлын цаг болон цалинг 20 хувиар бууруулсан тохиолдолд, мөн ажлын нөхцөл муудсан болон ажлын цагийг ажил олгогч өөрийн дураар өөрчлөн сар гарангийн хугацаанд ажиллуулсан тохиолдлууд үүнд хамаарна.
